

Өмгөөллийн “Соёмбо легал партнерс ХХН-ийн  
2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 01/122 тоот  
албан бичгийн Хавсралт 1

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Газрын тосны тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй.

#### **1/4 дүгээр зүйлийн 4.1.34, 4.1.35, 4.1.36, 4.1.37, 4.1.38 дахь заалт:**

“4.1.34.“ялгасан талбай” гэж газрын тос, уламжлалт бус газрын тосны хэтийн төлөвтэй гэж үзэн хайгуул хийхээр газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас тодорхойлсон талбайг;

4.1.35.“хөрөнгө оруулалт, хайгуулын ажлын доод хэмжээ” гэж бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан тухайн жилд заавал хийж гүйцэтгэх ажлыг эсхүл түүнтэй тэнцэх хөрөнгө оруулалтын мөнгөн дүнг;

4.1.36.“төрийн өмчийн оролцоотой газрын тосны компани” гэж газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахаар Засгийн газрын шийдвэрээр байгуулагдсан компанийг;

4.1.37.“хэмжилтийн цэг” гэж бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайд газрын тос, уламжлалт бус газрын тосыг худалдах зорилгоор ачилт хийх үед хэмжсэн цэгийг.”

4.1.38. ““Газрын тос боловсруулах төрийн өмчит үйлдвэр” гэж дотоодын түүхий эдэд түшиглэн газрын тос боловсруулах үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлж буй 100 хувь төрийн өмчит хуулийн этгээдийг”

#### **2/7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.16 дахь заалт:**

“7.1.1.газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах хөгжлийн бодлогыг боловсруулах;

7.1.16.төрийн өмчийн оролцоотой газрын тосны компани байгуулах.”

#### **3/7 дугаар зүйлийн 7.1.17 дахь заалт:**

7.1.17. “Газрын тос боловсруулах төрийн өмчит үйлдвэрийн газрын тос хийх, ашиглах үйл ажиллагаа явуулах тухай гэрээ байгуулах асуудлыг шийдвэрлэх”

#### **4/8 дугаар зүйлийн 8.1.12 дахь заалт:**

“8.1.12. Монгол Улсын нутаг дэвсгэрт хийгдсэн газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуулын ажлын үр дүнгийн болон нөөцийн тооцооны тайлан, орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөнд дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах үүрэг бүхий мэргэшсэн мэргэжилтнээс бүрдсэн гишүүдтэй Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл байгуулах, түүний дүрэм батлах.”

#### **5/9 дүгээр зүйлийн 9.1.24 дэх заалт:**

9.1.24. “Энэ хуулийн 7.1.17-д заасны дагуу олгогдсон талбайд хийгдсэн хайгуулын ажлын анхдагч өгөгдөл, боловсруулалт хийгдсэн өгөгдөл, тайлан, материал, мэдээллийг цахим хэлбэрээр, боломжгүй тохиолдолд бусад хэлбэрээр газрын тос боловсруулах төрийн өмчит үйлдвэрт хуулбарлан өгнө”

#### **6/27 дугаар зүйлийн 27.9 дэх хэсэг:**

“27.9. Хэмжилтийн цэг болон хүргэлтийн цэгийн хооронд гарах худалдан борлуулахтай холбоотой зардал нь борлуулалт, тээврийн зардал байна.”

#### **7/28 дугаар зүйлийн 28.3, 28.4, 28.4.1, 28.4.2 дахь хэсэг, заалт:**

“28.3. Газрын тос хадгалах зориулалтын савыг өмчлөгч нь улсын бүртгэлд бүртгүүлэхдээ газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалах зориулалтын савыг улсын бүртгэлд бүртгүүлэх журмын дагуу бүртгүүлнэ.

28.4. Газрын тос хадгалахад дараах зүйлийг хориглоно:

28.4.1. зориулалтын бус барилга байгууламжид, мөн улсын комисс хүлээн аваагүй байгууламжид газрын тос хадгалах;

28.4.2. стандартын шаардлага хангагүй саванд хадгалах.”

#### **8/42 дугаар зүйлийн 42.6 дахь хэсэг:**

“42.6. Гэрээлэгч нь байгалийн хий илэрсэн талаар төрийн захиргааны байгууллагад 30 хоногийн дотор мэдэгдээгүй бол уг талбайд байгалийн хийн хайгуул хийх нээлттэй сонгон шалгаруулалт зарлана.”

#### **9/25<sup>1</sup> дугаар зүйл, 25<sup>1</sup>.1, 25<sup>1</sup>.2 хэсэг:**

9/25<sup>1</sup> дугаар зүйл. Газрын тос боловсруулах төрийн өмчит үйлдвэрийн газрын тосны хайгуул, ашиглалт”

25<sup>1</sup>. Газрын тос боловсруулах төрийн өмчит үйлдвэр нь газрын тос хайх, ашиглах үйл ажиллагаанд Газрын тосны тухай хуулийн 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18.2, 19, 20, 21, 26, 32, 33, 34, 36 дугаар зүйлд зааснаас бусад зохицуулалтыг мөрдөн ажиллана.

25<sup>1</sup>. Газрын тос хайх, ашиглах үйл ажиллагаа нь газрын тос боловсруулах төрийн өмчит үйлдвэр болон гэрээлэгчийн хооронд байгуулсан гэрээгээр зохицуулагдана.

### **10/30 дугаар зүйлийн 30.9 дэх хэсэг:**

**30.9. “Газрын тос боловсруулах төрийн өмчит үйлдвэр нь Засгийн газраас олгосон талбайд газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулахад тусгай зөвшөөрлийн төлбөр төлөхгүй”**

**2 дугаар зүйл.** Газрын тосны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8, 4.1.20, 4.1.21, 4.1.24 дахь заалтын, 7 дугаар зүйлийн 7.1.14 дэх заалтын, 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалтын, 9 дүгээр зүйлийн 9.1.9, 9.1.12, 9.1.16, 9.1.18 дахь заалтын, 11 дүгээр зүйлийн 11.2.11, 11.2.13 дахь заалтын, 17 дугаар зүйлийн 17.7 дахь хэсгийн, 18 дугаар зүйлийн 18.13 дахь хэсгийн, 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийн, 23 дугаар зүйлийн 23.1, 23.3, 23.4 дэх хэсгийн, 24 дүгээр зүйлийн 24.4.1 дэх заалтын, 25 дугаар зүйлийн 25.10 дахь хэсгийн, 26 дугаар зүйлийн 26.1.1 дэх заалтын, 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалтын, 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсгийн, 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсгийн “газрын тосны” гэсний өмнө “газрын тос, уламжлалт бус” гэж, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн “төрийн” гэсний дараа “нийтийн” гэж, 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтын “баримтлах” гэсний дараа “хөгжлийн” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтын “өөрт ногдох” гэсний дараа, 11.2.14 дэх заалтын “зардлын тайлан,” гэсний дараа, 11 дүгээр зүйлийн 11.2.19 дэх заалтын, 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсгийн “газрын тосыг” гэсний өмнө, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн, 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсгийн “талбайн хэмжээг” гэсний дараа, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн “хайгуулын цооногоос” гэсний дараа, 25 дугаар зүйлийн 25.6 дахь хэсгийн “тохиолдолд тухайн” гэсний дараа, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийн, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийн “Олборлосон” гэсний дараа, 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалтын “газрын тос” гэсний өмнө, 29 дүгээр зүйлийн 29.2, 29.4 дэх хэсгийн, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийн “Гэрээлэгч” гэсний дараа, 35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсгийн “чулуун дээж,” гэсний дараа, 35.3 дахь хэсгийн “хилээр нэвтрүүлсэн” гэсний дараа, 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсгийн “талбайд хийгдэж байгаа” гэсний дараа “газрын тос, уламжлалт бус” гэж, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн “авсан газарт” гэсний дараа “хайгуулын талбайтай давхцуулалгүйгээр” гэж, 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсгийн “төслийг боловсруулж,” гэсний дараа “энэ хуулийн 34.5-д заасан нөхцөлийг ханган, энэ хуулийн 8.1.3-т заасан гэрээлэгчийг сонгон шалгаруулах тухай журамд заасан баримт бичгийн хамт” гэж, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн “авах тухай хүсэлтээ” гэсний дараа “гэрээ байгуулсан өдрөөс хойш 180 хоногийн дотор” гэж, мөн зүйлийн 18.3 дахь хэсгийн “баримт бичгийг” гэсний дараа “21 хоногийн дотор” гэж, 28 дугаар

зүйлийн гарчгийн “Газрын тос” гэсний дараа “, уламжлалт бус газрын тос” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Газрын тосны тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

**1/4 дүгээр зүйлийн 4.1.26 дахь заалт:**

“4.1.26.”нөөц ашигласны төлбөр” гэж хүргэлтийн цэг дээр хэмжсэн газрын тос, уламжлалт бус газрын тосонд ногдуулах төлбөрийг;”

**2/4 дүгээр зүйлийн 4.1.29 дэх заалт:**

“4.1.29.“олборлолтын зардал” гэж энэ хуулийн 4.1.18-д заасан үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг;”

**3/4 дүгээр зүйлийн 4.1.32 дахь заалт:**

“4.1.32.“өртөгт тос” гэж өртөг нөхөгдөх зардлыг нөхөхөд зориулж хүргэлтийн цэг дээр хэмжсэн нийт газрын тос, уламжлалт бус газрын тосноос энэ хуулийн 32.3-т заасан хувиар тооцсон газрын тос, уламжлалт бус газрын тосыг;”

**4/4 дүгээр зүйлийн 4.1.33 дахь заалт:**

“4.1.33.“ашигт тос” гэж хүргэлтийн цэг дээр хэмжсэн нийт газрын тос, уламжлалт бус газрын тосноос энэ хуулийн 4.1.26, 4.1.32-т заасан газрын тос, уламжлалт бус газрын тосыг хасаад Засгийн газар болон гэрээлэгчийн хооронд хуваах газрын тос, уламжлалт бус газрын тосыг;”

**5/7 дугаар зүйлийн 7.1.4 дахь заалт:**

“7.1.4.нөөц ашигласны болон тусгай зөвшөөрлийн төлбөр, орон нутгийг хөгжүүлэх урамшууллыг төлөх, хуваарилах, зарцуулах; газрын тосны бүртгэл, тооцоо; уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалттай холбогдсон харилцааг зохицуулах тухай журмыг батлах;”

**6/7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалт:**

“7.1.12. газрын тос болон уламжлалт бус газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээний загварыг тус тус батлах;”

**7/8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалт:**

“8.1.3.эрлийн ажил гүйцэтгэх гэрээний загвар; газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд тавих шаардлага; газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын анхдагч болон үр дүнгийн тайланд тавих

шаардлага; газрын тосны орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тавих шаардлага; гэрээлэгчийг сонгон шалгаруулах тухай; газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайг буцаан авах, өгөх, хүлээн авах; газрын тос, уламжлалт бус газрын тосны чиглэлээр мэргэжлийн зэрэг олгох, сургалтын урамшуулал, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэгийг зарцуулах журмыг батлах;”

#### **8/9 дүгээр зүйлийн 9.1.8 дахь заалт:**

“9.1.8.гэрээлэгчийн тухайн жилийн өртөг нөхөгдөх зардал, нөөц ашигласны төлбөр, өртөгт тос, ашигт тос, олборлосон болон борлуулсан газрын тос, уламжлалт бус газрын тосны тайланг хүлээн авч нэгтгэх, хяналт тавих;”

#### **9/9 дүгээр зүйлийн 9.1.14 дэх заалт:**

“9.1.14.байгалийн байдлаараа оршиж байгаа газрын тос, уламжлалт бус газрын тосны хураагуурын орон зайд газрын тос, уламжлалт бус газрын тос хадгалах зөвшөөрөл олгох;”

#### **10/10 дугаар зүйл:**

##### **“10 дугаар зүйл. Орон нутгийн байгууллагын эрх хэмжээ**

10.1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал газрын тосны асуудлаар дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

10.1.1.Газрын тосны тухай хууль болон холбогдох бусад хуулиар өөрт олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ улсын ашиг сонирхлыг харгалзаж, бодлого, шийдвэрээ хөгжлийн бодлоготой уялдуулах.”

10.1.2.газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул явуулах талбайг зарлах тухай мэдэгдлийг хүлээн авах;

10.1.3.татан буулгалтын ажлын үр дүнг хүлээн авах комиссын үйл ажиллагаанд оролцох, хамтран ажиллах;

10.2.Аймгийн Засаг дарга газрын тосны асуудлаар дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

10.2.1.газрын тосны тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан Засгийн газар болон харьяалах дээд шатны байгууллагын шийдвэрийн биелэлтийг нутаг дэвсгэртээ зохион байгуулах, үр дүнг хариуцах;

10.2.2.газрын тосны тухай хууль тогтоомжийг биелүүлэх ажлыг зохион байгуулахдаа холбогдох төрийн байгууллагуудтай хамтран ажиллах, үйл ажиллагаагаа уялдуулах;

10.2.3.энэ хуулийн 11.2.17-д заасныг үндэслэн байгуулсан сум, дүүргийн Засаг дарга болон гэрээлэгчтэй хамтран байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх асуудлыг тусгасан гэрээний хэрэгжилтэд хяналт тавих;

10.2.4.энэ хуульд заасны дагуу газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгчид дэмжлэг үзүүлэх;

10.2.5.эрх бүхий байгууллагаас газрын тостой холбогдуулан гаргасан шийдвэрийн талаар жил бүр харьяалах нутаг дэвсгэрийнхээ иргэдэд мэдээлэх.

10.3.Сум, дүүргийн Засаг дарга газрын тосны асуудлаар дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

10.3.1.газрын тосны тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан Засгийн газар болон харьяалах дээд шатны байгууллагын шийдвэрийн биелэлтийг хэрэгжүүлэх;

10.3.2.харьяалах нутаг дэвсгэртээ эрлийн гэрээ болон бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олгогдсон талбайг зориулалтаар нь ашиглуулах, эзэмшүүлэхэд хяналт тавих, зөрчил илэрсэн тохиолдолд холбогдох төрийн байгууллагад мэдэгдэж зөрчлийг таслан зогсоох, арилгуулах;

10.3.3.гэрээлэгч байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих;

10.3.4.энэ хуулийн 11.2.17-д заасныг үндэслэн байгуулсан сум, дүүргийн Засаг дарга болон гэрээлэгчтэй хамтран байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх асуудлыг тусгасан гэрээг байгуулах, хэрэгжүүлэх, харьяалах дээд шатны Засаг даргад тайлагнах;

10.3.5.энэ хуульд заасны дагуу газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгчид дэмжлэг үзүүлэх;

10.3.6.эрх бүхий байгууллагаас газрын тостой холбогдуулан гаргасан шийдвэрийн талаар жил бүр харьяалах нутаг дэвсгэрийнхээ иргэдэд мэдээлэх.

10.4.Багийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

10.4.1. газрын тосны тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй

холбогдон гарсан Засгийн газар болон харьяалах дээд шатны байгууллагын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах ажлыг хариуцах;

10.4.2.гэрээлэгч байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаа талаар дээд шатны Засаг даргад санал өгөх;

10.4.3.энэ хуулийн 11.2.17-д заасан гэрээнд санал өгөх.

**11/11 дүгээр зүйлийн 11.2.6 дахь заалт:**

“11.2.6.өртөг нөхөгдөх зардал, борлуулалтын орлого, зардалтай холбоотой гүйлгээг Монгол Улсад бүртгэлтэй арилжааны банкаар дамжуулан гүйцэтгэх бөгөөд уг гүйлгээг санхүүгийн тайланд ил тод, нээлттэй бүрэн тусгах;”

**12/11 дүгээр зүйлийн 11.2.9 дэх заалт:**

“11.2.9.хайгуул, ашиглалтын барилга байгууламжийг татан буулгах баталгаа болгон тухайн жилийн хайгуулын ажлын хөрөнгө оруулалтын гурван хувь, ашиглалтын үед гэрээлэгчид ногдох ашигт тосны нэг хувьтай тэнцэх мөнгөн хөрөнгийг жил бүр төлөвлөгөө батлагдсанаас хойш 60 хоногийн дотор Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг банкны эскроу дансанд байршуулах;”

**13/17 дугаар зүйлийн 17.3.4 дэх заалт:**

“17.3.4.хөрөнгө оруулалт, хайгуулын ажлын доод хэмжээ;”

**14/19 дүгээр зүйлийн 19.1.5 дахь заалт:**

“19.1.5.энэ хуулийн 12 дугаар зүйлд зааснаар бүтээгдэхүүн хуваах гэрээ нь цуцлагдсан, эсхүл энэ хуулийн 9.1.22, 11.1.5, 17.7, 42.6-д заасан нөхцөл байдал үүссэн;”

**15/22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг:**

“22.5.Олборлолтын туршилтаар олборлосон газрын тос, уламжлалт бус газрын тосыг худалдаж, экспортолж болох бөгөөд нөөц ашигласны төлбөр, өртөгт тос, ашигт тосны хэмжээг бүтээгдэхүүн хуваах гэрээгээр зохицуулна.”

**16/27 дугаар зүйлийн 27.1, 27.2, 27.3 дахь хэсэг:**

“27.1.Газрын тос, уламжлалт бус газрын тосны хүргэлтийн цэгийг худалдан авагчийн саналыг үндэслэн төрийн захиргааны байгууллага, гэрээлэгч харилцан тохиролцож тогтооно.

27.2.Газрын тос, уламжлалт бус газрын тосны хэмжилтийн цэгийг төрийн захиргааны байгууллага, гэрээлэгч нар харилцан тохиролцож тогтооно. Хэрэв хэмжилтийн цэгийн байршлын талаар талууд 30 хоногийн дотор тохиролцож чадаагүй бол төрийн захиргааны байгууллага хэмжилтийн цэгийг тогтооно.

27.3.Хүргэлтийн цэг болон хэмжилтийн цэг дээр хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар хэмжилт хийлгэнэ.”

**17/27 дугаар зүйлийн 27.5 дахь хэсэг:**

“27.5.Газрын тос, уламжлалт бус газрын тосны үнийг шинж чанар, зах зээл, байршил, өрсөлдөх чадвар зэргээс хамааруулан худалдан авагчийн саналыг үндэслэн төрийн захиргааны байгууллага болон гэрээлэгч харилцан тохиролцож тогтооно.”

**18/30 дугаар зүйлийн 30.6 дахь хэсэг:**

“30.6.Тусгай зөвшөөрлийн төлбөрийг Төсвийн тухай хуульд заасны дагуу хуваарилна.”

**19/31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг:**

“31.1.Газрын тос, уламжлалт бус газрын тосны нөөц ашигласны төлбөрийн хэмжээ нь борлуулсан газрын тос, уламжлалт бус газрын тосны 5-аас доошгүй хувь байна.”

**20/31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсэг:**

“31.3.Нөөц ашигласны төлбөрийг Төсвийн тухай хуульд заасны дагуу төвлөрүүлнэ.”

**21/32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэг:**

“32.1.Газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулахад шаардагдах бүх зардлыг гэрээлэгч хариуцна.”

**22/32 дугаар зүйлийн 32.3 дахь хэсэг:**

“32.3.Өртөгт тосны хэмжээ нь тухайн жилд борлуулсан нийт газрын тос, уламжлалт бус газрын тосноос нөөц ашигласны төлбөрт ногдох газрын тос, уламжлалт бус газрын тосыг хасаад үлдэх тосны 40 хүртэл хувь байна.”

**23/33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэг:**

“33.2.Ашигт тосны Засгийн газарт ногдох хэмжээг хоногт олборлох газрын тос, уламжлалт бус газрын тосны хэмжээтэй уялдуулан бүтээгдэхүүн хуваах гэрээнд тодорхойлон заана.”

## **24/42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг:**

“42.1.Хайгуулын явцад байгалийн хий илэрсэн тохиолдолд төрийн захиргааны байгууллагад 30 хоногийн дотор мэдэгдэх бөгөөд тухайн гэрээлэгчтэй байгалийн хийн талаар тусад нь гэрээ байгуулж болно.”

**4 дүгээр зүйл.**Газрын тосны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.17 дахь заалтын “бүтцийг хүргэлтийн цэг хүртэл” гэснийг “бүтэц” гэж, 4.1.19 дэх заалтын “гэрээний хугацаа дуусгавар болох үед гэрээлэгчээс” гэснийг “гэрээ дуусгавар болох үед” гэж, 4.1.23 дахь заалтын “газрын тосны орд” гэснийг “газрын тос, уламжлалт бус газрын тосны орд” гэж, 4.1.25 дахь заалтын “газрын тосыг Монгол Улсын нутаг дэвсгэрт” гэснийг “газрын тос, уламжлалт бус газрын тосыг” гэж, 4.1.31 дэх заалтын “үйл ажиллагаа,” гэснийг “олборлолт,” гэж, 5 дугаар зүйлийн гарчгийн, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн, 25 дугаар зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 25.5 дахь хэсгийн, 27 дугаар зүйлийн гарчгийн “Газрын тосны” гэснийг “Газрын тос, уламжлалт бус газрын тосны” гэж, “7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтын дугаарыг 7.1.2 гэж, 7.1.2 дахь заалтын дугаарыг 7.1.3 гэж, 7.1.3 дахь заалтын дугаарыг 7.1.4 гэж, 7.1.4 дэх заалтын дугаарыг 7.1.5 гэж, 7.1.5 дахь заалтын дугаарыг 7.1.6 гэж, 7.1.6 дахь заалтын дугаарыг 7.1.7 гэж, 7.1.7 дахь заалтын дугаарыг 7.1.8 гэж, 7.1.8 дахь заалтын дугаарыг 7.1.9 гэж, 7.1.9 дэх заалтын дугаарыг 7.1.10 гэж, 7.1.10 дахь заалтын дугаарыг 7.1.11 гэж, 7.1.11 дэх заалтын дугаарыг 7.1.12 гэж, 7.1.12 дахь заалтын дугаарыг 7.1.13 гэж, 7.1.13 дахь заалтын дугаарыг 7.1.14 гэж, 7.1.14 дэх заалтын дугаарыг 7.1.15 гэж, мөн зүйлийн 7.1.6 дахь заалтын “газрын тос өртөгт газрын” гэснийг “ашигт тос болон өртөгт” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.11 дэх заалтын “газрын тос борлуулах” гэснийг “газрын тос, уламжлалт бус газрын тос тээвэрлэх” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтын дугаарыг 8.1.1 гэж, 8.1.3 дахь заалтын дугаарыг 8.1.2 гэж, 8.1.4 дэх заалтын дугаарыг 8.1.3 гэж, 8.1.5 дахь заалтын дугаарыг 8.1.4 гэж, 8.1.6 дахь заалтын дугаарыг 8.1.5 гэж, 8.1.7 дахь заалтын дугаарыг 8.1.6 гэж, 8.1.8 дахь заалтын дугаарыг 8.1.7 гэж, 8.1.9 дэх заалтын дугаарыг 8.1.8 гэж, 8.1.10 дахь заалтын дугаарыг 8.1.9 гэж, 8.1.11 дэх заалтын дугаарыг 8.1.10 гэж, 8.1.12 дахь заалтын дугаарыг 8.1.11 гэж, 9 дүгээр зүйлийн 9.1.20 дахь заалтын “тус шийдвэрээ төрийн захиргааны төв байгууллагад урьдчилан мэдэгдсэн байх;” гэснийг “эсэх талаар шийдвэрийн төслийг төрийн захиргааны төв байгууллагад урьдчилан мэдэгдэж, санал авах;” гэж, 11 дүгээр зүйлийн 11.2.5 дахь заалтын “Монгол Улсад бүртгэлтэй татвар төлөгч аж ахуйн нэгжид” гэснийг “дотоодын хөрөнгө оруулагчид” гэж, мөн зүйлийн 11.2.20 дахь заалтын “шүүхийн шийдвэр болон” гэснийг “төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны болон шүүхийн шийдвэр, иргэдийн эсэргүүцэл,” гэж, 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсгийн “хоёр ба түүнээс дээш хуулийн этгээд” гэснийг “ирүүлснээс хойш

ажлын 5 хоногт дараагийн хуулийн этгээд” гэж, 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн “тайланг төрийн захиргааны байгууллагаар дүгнэлт” гэснийг “тайлан болон эрлийн гэрээний хэрэгжилтийн талаарх дүгнэлтийг төрийн захиргааны байгууллагаар” гэж, 17 дугаар зүйлийн 17.3.3 дахь заалтын, 32 дугаар зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 32.2 дахь хэсгийн “өртөгт газрын” гэснийг “өртөгт” гэж, 7 дугаар зүйлийн 7.1.5 дахь заалтын, 11 дүгээр зүйлийн 11.2.9 дэх заалтын, 17 дугаар зүйлийн 17.3.1 дэх заалтын, 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийн, 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийн, мөн зүйлийн 33.2 дахь хэсгийн “ашигт газрын” гэснийг “ашигт” гэж, 24 дүгээр зүйлийн 24.4 дэх хэсгийн “ирүүлнэ:” гэснийг “ирүүлэх бөгөөд төрийн захиргааны төв байгууллага 21 хоногийн дотор ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгох эсэхийг шийдвэрлэнэ.” гэж, 25 дугаар зүйлийн 25.8 дахь хэсгийн “90 хоногийн өмнө төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ” гэснийг “90 хоногийн дотор төрийн захиргааны байгууллагад ирүүлж, эхний улиралд багтаан батлуулна” гэж, 27 дугаар зүйлийн 27.6 дахь хэсгийн “олборлосон газрын тосыг хүргэлт болон хяналтын” гэснийг “газрын тос, уламжлалт бус газрын тосыг хүргэлт болон хэмжилтийн” гэж, 31 дүгээр зүйлийн 31.1.3 дахь заалтын дугаарыг 31.1.2 гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.** Газрын тосны тухай хуулийн 4.1.18 дахь заалтын “хүргэлтийн цэг хүртэлх” гэснийг, 4.1.25 дахь заалтын “Монгол Улсын нутаг дэвсгэрт” гэснийг, 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтыг, 11 дүгээр зүйлийн 11.2.17 дахь заалтын “сайн дурын үндсэн дээр” гэснийг, 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалтын “биелүүлээгүй буюу” гэснийг тус тус хассугай.

**6 дугаар зүйл.** Газрын тосны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, 31 дүгээр зүйлийн 31.2 дэх хэсгийг хүчингүйд болсонд тооцсугай.

**7 дугаар зүйл.** Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

---оОо---